



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 18 өдөр

Дугаар А/639

Есөнбулаг

Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны 07 дугаар сарын 09-ны өдрийн А/172,116 дугаар ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний зардлын нормативыг шинээр болон шинэчлэн батлах тухай, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.9 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Улсын төсвийн хөрөнгөөр Цээл сумын шинэ суурьшлын бүсэд 10 га талбайд навчит модны тарьц болон загийн бортоготой тарьцаар ойжуулалт хийсэн ажлын гүйцэтгэлийг хүлээн авах, сумын орон нутгийн хөрөнгөнд бүртгэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Д.Батмагнай	(Байгаль орчны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Гишүүд:	Б. Цэрэнбал	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн байгаль орчин, геологи уул уурхай, аялал жуулчлалын бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн)
	М. Мандаххүү	(Аймгийн Засаг Даргын Тамгын газрын Архивын тасгийн дарга)
	Ч.Алтангэрэл	(Байгаль орчны газрын уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн)
	Ж.Билэгсайхан	(Орон нутгийн өмчийн газрын өмчийн бүртгэл, ашиглалт хариуцсан ахлах мэргэжилтэн)
	Б.Эрдэнэчимэг	(Сум дундын ойн ангийн мэргэжилтэн)
	Б.Насанбуян	(Цээл сумын Засаг даргын Тамгын газрын дарга)
	Т.Лхамжав	(Цээл сумын Засаг даргын Тамгын газрын байгаль орчны хяналтын улсын байцаагч)
	Д.Луухүү	(Цээл сумын Засаг даргын Тамгын газрын хөдөө аж ахуй, газар тариалан хариуцсан мэргэжилтэн)

Н.Насанжаргал (“Эко лайн еэс” ХХК-ийн захирал)  
(гүйцэтгэгч)

Нарийн бичгийн дарга: Б.Пүрэвдорж (Байгаль орчны газрын ой,  
ургамал байгалийн гамшигийн  
асуудал хариуцсан мэргэжитэн)

2.Улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн Цээл сумд 10 га талбайд хийгдсэн ойжуулалтын ажлыг хүлээн авахдаа гэрээнд тусгагдсан ажлын даалгавар, холбогдох баримт бичгийн бүрдлийг хүлээн авч, үр дүнг 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн дотор танилцуулахыг комисс (Д.Батмагнай)-т үүрэг болгосугай.

3.Хөрөнгийг бүртгэж, ашиглалтад хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг)-т, ашиглалт, арчилгаа, хамгаалалтыг хариуцаж ажиллахыг Цээл сумын Засаг дарга (Д.Буянхишиг)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ